



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 онь 06 сарын 08 өдөр

Дугаар А/146


Онги

Г Хорио цээрийн дэглэм тогтоож, отрын Г
бүс нутагт хязгаарлалтын арга
хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 02 дугаар хавсралтаар баталсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Найз багийн нутаг “Их өндөр” гэх газарт малын гоц халдварт бог малын мялзан өвчин гарч онош нь баталгаажиж сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 28 хоногийн хугацаанд хорио цээрийн дэглэм тогтоосугай.
2. Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан өөр аймаг, сумын отрын малчдын оторлуулах бүс нутгийг хавсралтаар баталсугай.
3. Малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан Онги, Мааньт, Найз, Төгрөг багуудын нутаг дэвсгэрт хавсралтад заасан отрын бүс нутагт отроор яваа гадны аймгийн малчин өрхүүдийг нутаглуулж, хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасаг болон багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Хорио цээрийн дэглэмийг журмын дагуу явуулж, хөдөлгөөн пост ажиллуулж, хяналт тавьж нийгмийн хэв журмыг сахиулан ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (С.Болоржаргал), хэсгийн төлөөлөгч (Ш.Ууганбаяр) нарт үүрэг болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж тухай бүр мэдээллээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг, багийн Засаг даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЛУВСАНРАГВА